



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 318

Улаанбаатар хот

“Талын зам” төрийн өмчит хувьцаат
компанийн 2018 оны төлөвлөгөөнд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн “Талын зам” төрийн өмчит хувьцаат компанийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах тухай” 619 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт дахь “...хөрөнгө оруулалт 87,000.0 мян.төгрөг...” гэснийг “...хөрөнгө оруулалт 136,500.0 мян.төгрөг...” гэж өөрчилсүгэй.

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 619 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Талын зам” төрийн өмчит хувьцаат компанийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хавсралтад заасан хөрөнгө оруулалтыг нэмсүгэй.

3.Компанийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан 2018 оны бизнес төлөвлөгөө болон худалдан авалтын төлөвлөгөөнд зохих нэмэлт өөрчлөлт оруулан баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд үүрэг болгосугай.

4.Төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр, авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч, худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг гүйцэтгэх захирал Т.Бямбадоржид даалгасугай.

5.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА




Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0002097

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018
оны ~~04~~ дугаар сарын ~~09~~ ны өдрийн
~~318~~ дугаар тогтоолын хавсралт



"ТАЛЫН ЗАМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД НЭМЭХ ХӨРӨНГӨ

№	Хөрөнгө оруулалтын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /мян.төг/	Нийт үнэ /мян.төг/
1	Индүү	ширхэг	1	49,500.0	49,500.0
	ДҮН				49,500.0